



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Н.ГАНБЯМБА ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.02.18 № 05/2138
танай 2019.02.21 ны № 9/330-382

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Шашиймаагийн Оюунжаргал, Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Базаргүрийн Ганцэцэг, Хэрлэн сумын яслийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Дашзэвэгийн Золзаяа нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байрны тодорхойлолтын тавигдах шаардлагын мэргэжил хэсэгт сургуулийн өмнөх боловсролын багш байх гэж заасныг нэр дэвшигч Ш.Оюунжаргал нь хангаагүй байгааг анхаарна уу.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигчид нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Хашбаатар* Х.ХАШБААТАР



0003891